

Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

Сүмийн
удирдагч
Есүс дээр
ирсэн нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Byron Unger; Lazarus

Найруулсан: M. Maillot; Sarah S.

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Нэгэн өдөр Есүс сүмд орж ирээд Бурханы
өргөөг үл хүндэтгэсэн хүмүүсийг олж харав.
Тэд сүм дотор мал амьтан зарж мөнгө
солилцож байлаа.**



Тэр дээсээр шилбүүр хийж, хонь үхэр бүгдийг нь сүмээс туун гаргаад, мөнгө солигчдын зооснуудыг тараан хаяж ширээг нь хөмрүүлэв.




Тэгээд "Энэ юмнуудаа зайлуул" гэж тушаав.
"Миний Эцгийн гэрийг наймааны газар болгохоо
зогсоо" гэлээ. Есүс Эцгийнхээ гэрийг хайрласандаа
ТЭГЖЭЭ.





Харин сүмийн
ахлагч нар
Есүсийг сүмийг
цэвэрлэх эрхтэй
гэдгээ харуулж
тэмдэг үзүүлэхийг
шаарджээ. Есүс
"Энэ сүмийг устга
би үүнийг гурав
хоногийн дотор
дахин босгох
болно" гэв.





Байж
боломгүй юм!
Энэ сүмийг
барихад дөчин
зургаан жил
зарцуулсан
билээ.



**Гэвч Есүс өөрийн биеийн талаар
ярьжээ. Ариун сүмийн нэгэн
адил, Түүний бие Бурханы
орших газар юм. Есүс
загалмай дээр нас
бараад Бурхан түүнийг
гурван өдрийн дотор
амилуулна гэдгийн
тухай ярьж
байсан юм.**





Нэгэн орой
сүмийн ахлагч
нарын нэг Есүс
дээр иржээ. Тэр
Есүсийн үйлдсэн
гайхамшгуудыг
хараад тэр бол
Бурханаас
илгээгдсэн нэгэн
гэдэгт итгэсэн байв.
Никодем Есүс дээр
ирж Бурханы
тараар илүү ихийг
мэдэхийг хүсжээ.





Есүс Никодемд
хүн дахин төрж
байж тэнгэрийн
хаанчлалд орно гэв.
Никодем үүнийг
сайн ойлгосонгүй.
Насанд хүрсэн хүн
яаж дахин төрөх
вэ? Тэрээр их сүсэг
бишрэлтэй хүн байв.
Сүсэг бишрэлтэй их
байлаа ч тэнгэрийн
хаанчлалд ороход
хангалтгүй
гэж үү?





Сүнснээс төрсөн
нь сүнс юм гэж
Есүс тайлбарлав.
Бурханы сүнс бол
салхи адил юм.
Хүмүүс салхийг
харж бас хаашаа
явсныг нь
мэддэггүй. Тэд
зөвхөн салхи юу
хийснийг нь
хардаг.






Есүс Никодемд олон жилийн өмнө Израйлийн хөвгүүд Мосед гомдоллож "Бидэнд идэх юм алга, уух ус алга бид Бурханы өгсөн талхыг үзэн ядаж байна" гэж хашхирч байсныг сануулав.



Тэр үед хүмүүсийн нүгэл нь
Бурханыг уурлуулсан юм.
Тэр тэдэн уруу галт могой
илгээв. Могойд хатгуулснаас
болж олон хүн үхсэн юм.



**Хүмүүс "Бид нүгэл
үйлджээ". Биднээс могойнуудыг
холдуулаач гэж залбирч өгөөч
хэмээн Мосегоос гуйжээ. Тиймээс
Мосе тэдний төлөө залбирав.
Гэвч Бурхан могойнуудыг
холдуулсангүй.**



**Бухан Мосед -Галт
могой хийж, түүнийг шургааны
оройд байрлуулагтун. Тэгвэл
хатгуулсан хүн бүр түүнийг
хараад амьдрах болно гэж амлав.
Мосе хүрэл могойг хийж, түүнийг
шургааны оройд байрлуулав
тэгээд хүрэл могойг харсан
хүн болгон эдгэрч байв.**





Есүс Никодемд
Хүний хүү ч бас
хүрэл могой адил
өргөгдөх
ёстой гэв.





Энэ нь Есүс өөрөө
нүгэлтэнүүдийн
төлөө нас барах
загалмайн
тухай хэлсэн
ЮМ.





Есүс "Бурхан ертөнцийг
үнэхээр хайрласан бөгөөд
цорын ганц хүүгээ
илгээсэн ба хүүд
итгэгч хэн ч мөхөхгүй
харин мөнх амьтай
болох юм" гэлээ.





Энэ бол Есүст итгэсэн
хэн боловч Бурханы
гэр бүлийн гишүүн
болно гэсэн
үг юм.



**Никодем тэр шөнө Есүсийн дагалдагч болсонгүй.
Гэвч нэг жилийн дараа тэр цовдлогдсон
Бурханы Хүүг оршуулхад
туслан Есүст итгэдэг
бөгөөд хайртайгаа
батлан харуулсан юм.**



Үүний дараа Есүс дагалдагч нартайгаа хойд зүг уруу аялав. Энэ нь бусад хүмүүст Бурханы хаанчлалын сайн мэдээг хүргэж Бурханы хүү Есүст итгэх боломж олгохын тулд байлаа.



Сүмийн удирдагч Есүс дээр ирсэн нь

Бурханы үг Библээс авсан түүх

Иохан 2-3, Тооллого 21

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

